



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А1569

Есөнбулаг

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2 дахь заалт, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дах заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 26 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1 дэх зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сургуулийн суралцагчдыг бүтээлч оролцоонд тулгуурлан EQ чадварыг хөгжүүлэх сургалт зохион байгуулахад Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын Хоёрдугаар сургууль (Э.Тэрбиш)-д дэмжлэг үзүүлсүгэй.

2. Шаардагдах 5,000,000 (Таван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Ж.Амгаланбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ